



ДОРНОД АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/20

Чойбалсан

Г Эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 203, 207, 314, 373, 378 дугаар тушаалуудыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Коронавируст халдвар (Ковид-19)-ын тохиолдол нэмэгдэж байгаатай холбогдуулан Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн албаны бэлэн байдлыг хангуулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн захирал, дарга нарт ДААЛГАХ нь:

1.1.Хүн амд коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг нэмэлт тунгийн дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлж, эрчимжүүлэх, дархлаажуулалтын ач холбогдол, сум, орон нутгийн халдварын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сум, орон нутаг эрүүл мэндийн байгууллагын өөрийн пэйж хуудсаар мэдээллийг түгээж ажиллах,

1.2.Уул уурхай, цэргийн анги, асрамж зэрэг олон хүн хуарангасан газар урьдчилан сэргийлэх чиглэлээр тандалтын түүврийн шинжилгээг хийх, коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх сургалт сурталчилгаа хийх,

1.3.5-11,12-17 насны хүүхдүүдийг коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх дархлаажуулалтад хамруулах ажлыг харъяа боловсролын байгууллагуудтай хамтран зохион байгуулах,

1.4.Тухайн орон нутагт аялал зугаалга, Улаанбаатар хот болон бусад аймаг, орон нутгаас ирсэн, олон нийтийн арга хэмжээнд оролцсон иргэдийг 2-3 хоног гэрээр тусгаарлах, сайн дурын тандалтын шинжилгээнд хамруулахыг уриалах,

1.5.Коронавируст халдвар (Ковид-19) тухайн орон нутгийн хүн амын дунд тархах эрсдэлийг үнэлэн, халдвараас сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж мөрдөгдөж буй тушаал, шийдвэр, журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх,

1.6.Хариу арга хэмжээний баг, тандалтын багийг өргөжүүлж ажиллах,

1.7.Коронавируст халдвар Омикрон хувилбарын тандалтын шинжилгээг тогтоох сорьцыг Халдварт өвчин судлалын үндэсний төвд илгээх,

310422053

1.8.Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сумын эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тохиолдолд ор дэлгэх, хүний нөөц, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хэрэгсэл болон бусад хэрэгцээг тооцоолон нөөцийг бүрдүүлэх,

1.9.Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан бүрийг холбогдох зааврын дагуу хамгаалах хувцас хэрэгслээр бүрэн хангаж, хамгаалах хувцас хэрэгслийг өмсөж тайлах дадлыг эзэмшүүлэх сургалтыг тасралтгүй тогтмол зохион байгуулах, голомтонд ажиллах багийг давтан сургах,

1.10.Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгчийн эрэмбэлэн ангилалтыг сайтар хийж, сэжигтэй болон батлагдсан тохиолдол илэрсэн нөхцөлд бусад үйлчлүүлэгчтэй холихгүй байх урсгал хөдөлгөөний зохицуулалт хийх,

1.11.Эмнэлэгт ирж буй үйлчлүүлэгч бүрээс тархвар судлалын асуумж авч, эмнэлэгт суурилсан тандалтыг өргөжүүлэх,

Хоёр.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллахыг Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтэс /Я.Эрдэнэтуяа/, Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Ч.Оюунтунгалаг/, Нийгмийн эрүүл мэндийн төв /Б.Сарнай/ нарт даалгасугай

ДАРГА



Ч.ОЮУНАА